



ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Эрүүгийн хэрэг)¹

БЭЛГЭВЧ ХЭРЭГЛЭСЭН ХЭМЭЭН ХОХИРОГЧИЙГ ХУУРЧ БЭЛГИЙН ХАРЬЦААНД ОРСНЫГ ГЭМТ ХЭРЭГ ГЭЖ ҮЗЭВ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 3 StR 372/22

Шүүхийн шийдвэрийн огноо: 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Шийдвэрийн төлөв байдал: Муж улсын шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгосон.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч болон хохирогч нь бэлгэвчтэйгээр бэлгийн харьцаанд орохоор тохиролцсон байна. Шүүгдэгч унтлагын өрөөн дэх шүүгээний шургуулгыг онгойлгон, бэлгэвч авч уутнаас нь гаргасан. Энэхүү үйл явцыг хохирогч харсан учраас түүнийг хэрэглэнэ хэмээн итгэжээ. Гэвч бодит байдал дээр шүүгдэгч уутнаас нь гаргасан ч хэрэглээгүй байна. Бэлгийн харьцааны явцад хохирогч үүнийг анзаарч, эсэргүүцэл үзүүлэн, шүүгдэгчийг үйлдлээ зогсохыг шаардаж, түүний гэрийг орхин явжээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хууль (1871)²-ийн тусгай ангид заасан бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн шинжид 2016 онд нэмэлт, өөрчлөлт орсон.³ Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс өмнө бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг хохирогчийн эсрэг хүч хэрэглэсэн, заналхийлсэн, эсвэл тусламж гуйх боломжгүй байдлыг далимдуулан бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийсэн хэмээн хуульчилж байжээ. Харин Эрүүгийн хуулийн 2016 оны нэмэлт, өөрчлөлтөөр хууль тогтоогч **ҮГҮЙ ГЭДЭГ НЬ ҮГҮЙ Л ГЭСЭН ҮГ** (гер.*Nein heißt Nein-Lösung*) гэх шийдлийг Эрүүгийн хуульд тусгахыг зорьж, **гэмт этгээд бусдын илэрхий хүсэл зоригийн эсрэг бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийснийг** бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг хэмээн хуульчилсан байна. Уг нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд тус улсын эрүүгийн эрх зүйн онолд **“Stealthing”** гэх ухагдахуун бий болсон бөгөөд энэхүү ухагдахууныг бэлгийн харьцаанд орох гэж буй хүнд бэлгэвч хэрэглэж

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

<https://juris.bundesgerichtshof.de/cgi-bin/rechtsprechung/document.py?Gericht=bgh&Art=en&sid=75cd63cbb6b9161b2f77f710ffcc0ddf&nr=132441&pos=0&anz=1>, Шүүхийн шийдвэрийг хураангуйлахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.

² Strafgesetzbuch (StGB), 1871,

<https://www.gesetze-im-internet.de/stgb/BJNR001270871.html#BJNR001270871BJNG006603307>

(Сүүлд үзсэн: 2025.03.12).

³ Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт, 2016, *Fünfzigstes Gesetz zur Änderung des Strafgesetzbuches - Verbesserung des Schutzes der sexuellen Selbstbestimmung*,

<https://dip.bundestag.de/vorgang/gesetz-zur-%C3%A4nderung-des-strafgesetzbuches-verbesserung-des-schutzes/73418>



байгаа хэмээн худал хэлж, бэлгийн харилцаанд орсон үйлдлийг тайлбарлахад ашигладаг байна.

Дээрх хэргийн хувьд прокурор шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт⁴ заасан хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хэмээн үзэж яллах дүгнэлт үйлджээ. Харин **Мужийн шүүхээс** прокурорын зүйлчлэлийг өөрчлөн шүүгдэгч Эрүүгийн хуулийн 177 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт⁵ заасан бусдын илэрхий хүсэл зоригийн эсрэг бэлгийн шинжтэй үйлдэл хийсэн гэж үзэж, шүүгдэгчид 3 жилийн хорих ял оногдуулсан байна. Шүүгдэгч Мужийн шүүх хэргийг шийдвэрлэхдээ материаллаг болон процессын хуулийг тус тус зөрчсөн гэсэн агуулгаар хяналтын гомдол гаргажээ.

Холбооны дээд шүүх гомдлын үндсэн дээр шүүхийн шийдвэрийг хянаад мужийн шүүх хэргийг шийдвэрлэхдээ **процессын хуулийг ноцтой зөрчсөн харин материаллаг хуулийг зөв хэрэглэсэн гэжээ**. Өөрөөр хэлбэл шүүгдэгчийн гаргасан процессын зөрчилтэй холбоотой гомдлыг хангаж, бусад гомдлыг хангаагүй байна.

Материаллаг хууль зөрчсөн гэх гомдолтой холбогдуулан хийсэн Холбооны дээд шүүхийн дүгнэлт

Холбооны дээд шүүхээс хэргийг хянаад мужийн шүүх шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 177 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн хэмээн зөв дүгнэсэн байна гэжээ. **Хохирогч зөвхөн бэлгэвчтэйгээр бэлгийн харилцаанд орохыг зөвшөөрсөн тохиолдолд шүүгдэгч түүнийг хуурч бэлгэвч хэрэглэхгүйгээр бэлгийн харилцаанд орсныг бусдын илэрхий хүсэл зоригийн эсрэг бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийсэн гэж үзнэ**. Хамгаалах хэрэгсэл хэрэглэж болон хэрэглэхгүйгээр бэлгийн харилцаанд орох нь ялгаатай ойлголт бөгөөд хамгаалалтгүй бэлгийн харилцаанд орох нь халдварт өвчин тусах, хүсээгүй жирэмслэлт бий болгох эрсдэлтэй байдаг. Иймээс хамгаалах хэрэгсэл хэрэглэсэн болон хэрэглэхгүйгээр бэлгийн харилцаанд орохыг адилтгаж үзэхгүй гэжээ.

Процессын хууль зөрчсөн гэх гомдолтой холбогдуулан хийсэн Холбооны дээд шүүхийн дүгнэлт:

Холбооны дээд шүүхээс Мужийн шүүхийн шийтгэх тогтоолыг Эрүүгийн процессын хуулийн 265 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт⁶ заасан **Шүүх яллах дүгнэлтэд дурдсан хууль зүйн дүгнэлтээс өөр дүгнэлт гаргах бол шүүгдэгчид энэ талаар тусгайлан мэдэгдэнэ гэснийг зөрчсөн** гэжээ.

⁴ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт. *Гэмт этгээд хохирогчийн хүсэл зоригоо илэрхийлэх чадваргүй байдлыг ашиглан бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийсэн, бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгүүлсэн, эсвэл бусдыг гуравдагч этгээдтэй бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгүүлсэн бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.*

⁵ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 177 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. *Бусдын илэрхий хүсэл зоригийн эсрэг бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийсэн, бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгүүлсэн, эсвэл бусдыг гуравдагч этгээдтэй бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгүүлсэн бол зургаан сараас таван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.*

⁶ Strafprozeßordnung (StPO), 1950,

<https://www.gesetze-im-internet.de/stpo/BJNR006290950.html#BJNR006290950BJNG000102311>,

(Сүүлд үзсэн: 2025.03.12).



Прокурорын яллах дүгнэлтэд шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-т зааснаар хохирогч хүсэл зоригоо илэрхийлэх чадваргүй байдлыг далимдуулан бэлгийн харилцааны шинжтэй үйлдэл хийсэн хэмээн үзсэн бол хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн мужийн шүүх **шийдвэртээ прокурорын зүйлчлэлийг өөрчлөн** Эрүүгийн хуулийн 177 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хохирогчийн илэрхий хүсэл зоригийн эсрэг бэлгийн харилцааны шинжтэй үйлдэл хийсэн хэмээн дүгнэжээ.

Хууль зүйн дүгнэлттэй холбоотой дээрх өөрчлөлтийг шүүгдэгчид мэдэгдээгүй бөгөөд энэ нь Эрүүгийн процессын хуулийн 265 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан **Шүүх яллах дүгнэлтэд дурдсан хууль зүйн дүгнэлтээс өөр дүгнэлт гаргах бол шүүгдэгчид энэ талаар тусгайлан мэдэгдэнэ гэснийг зөрчсөн** байна. Шүүгдэгч ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхтэй бөгөөд ийнхүү мэдсэнээр өөрийгөө зохих ёсоор өмгөөлөх эсхүл өмгөөлүүлэх эрх нь хэрэгжих нөхцөл бүрддэг. Иймээс хууль тогтоогчоос хууль зүйн дүгнэлтийн өөрчлөлтийг шүүгдэгчид мэдэгдэхийг дээрх зохицуулалтаар шүүхэд үүрэг болгожээ. Шүүгдэгчид яллах дүгнэлтэд заасан зүйл, заалтыг шүүх өөрчлөн зүйлчлэх талаар мэдэгдсэн тохиолдолд шүүгдэгч өөрийгөө үр дүнтэй өмгөөлж, энэ нь шүүхийн шийдвэрт нөлөөлж болох байсныг үгүйсгэхгүй хэмээн хяналтын шатны шүүх үзсэн байна.

---oOo---